

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 13-ний өдрийн 4 дугаар
тушаалын аравдугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Дэд бүтэц хариуцсан инженер	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Дэд бүтэц хариуцсан дэд зохицуулагч	

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэрэгжүүлэх төслийн инженерийн дэд бүтцийн ажлууд болох цахилгаан, дулаан, ус хангамжийн шугам сүлжээ, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, автозам, харилцаа холбооны шугам сүлжээ, холбогдох барилга угсралтын бүх ажлын хэрэгжилтийг хянах үүрэгтэй.		
2. Ажлын байрны дэд зорилтууд:	- Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй багийн инженерүүдийг удирдлагаар хангах, төсөлтэй холбоотой ТЭЗҮ, зураг төслийн ажилд хяналт тавих, зөвлөх багийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагатай уялдаа холбоогоор хангаж ажиллах - Барилга угсралтын ажил гүйцэтгэгчдээс ирүүлсэн ажлын төлөвлөгөө, зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу; ажил дуусах хүртэлх барилгын норм, зураг төсөл, техникийн нөхцөл, холбогдох бусад дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн эсэхийг баталгаажуулах, бүтээн байгуулалтыг шалгах, үнэ цэний инженерчлэл хийх, зардлыг оновчтой болгох зэрэг - Бүх дэд төслүүд дотоодын хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, үр дүнтэй мониторинг хийх; - Ажлын тоо хэмжээ, хяналтын гарын авлагын материал болон бусад холбогдох техник, инженерийн баримт бичгийг хянах.		
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/ хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1. Барилгын ажил, зураг төсөл, техникийн нөхцөл, гэрээ, хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг хянах, ажлын явцыг тогтмол хянах;	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан,	

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талбайд тогтмол үзлэг шалгалт хийж, аливаа асуудал, үл нийцэл, гомдлыг илрүүлэн, инженерийн стандарт, туршлагад үндэслэн холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөн урьдчилан сэргийлэх болон засах арга хэмжээ авах; 3. Дэд бүтцийн төслийн үнэлгээ, зураг төслийн оновчлол, бусад сайжруулалт, тооцоолол болон тендерийн баримт бичгийг инженерийн зөвлөхүүдтэй хамтран хянах; 4. Үе шат 1, 2, 3-ийн зураг төслийн зөвлөхтэй нягт хамтран ажиллаж, гүйцэтгэлийн боломжийн дүн шинжилгээ болон үнэ цэний инженерчлэлийн үнэлгээг хэрэгжүүлэх; 5. Дэд бүтцийн байгууламжийн хууль эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудлаар холбогдох төрийн болон орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөх туршлагатай байх; 6. Монгол Улсын барилгын стандарт, инженерийн дүрэм журмын шаардлагын талаар мэдлэгтэй, бодит туршлагатай байх; 7. Зураг төсөл болон хяналт-шинжилгээний ажлыг олон салбарын оролцоотой мэргэжлийн орчинд удирдан чиглүүлэх, бусад мэргэжилтнүүдтэй уялдаа холбоотой ажиллах; 8. Төслийн хэрэгжилтийн нэгж болон зөвлөхүүдтэй уялдаа холбоотой ажиллаж, гэрээний шаардлагын дагуу хуваарь, баримт бичгийн бүрдэл, гүйцэтгэлийг хангах; 9. Дэд бүтцийн асуудал хариуцсан төслийн дэд зохицуулагч болон төслийн зохицуулагчаас өгсөн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.		сар, улирал, жилийн тайлан
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт Боловсрол	Чухал шаардлагатай Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх	Шаардлагатай Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй бол давуу тал болно.
------------------------------------	-----------------------	-----------------------	--	--

		Мэргэжил	Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж /07/	
		Туршлага	Инженерийн болон төслийн менежментийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, нарийвчилсан инженерийн зураг төсөл, төслийн удирдлага, хяналтын чиглэлээр өргөн мэдлэгтэй, батлагдсан практик туршлагатай байх.	Зөвлөх инженерүүдийн олон улсын холбоо /FIDIC/-ны жишиг гэрээний дагуу ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
		Ур чадвар	Англи хэлний аман болон бичгийн харилцааны өндөр ур чадвартай байх	
	1.2.Тусгай шаардлага	Дэд бүтэцтэй холбоотой төслүүдэд ажиллаж байсан бол давуу тал болно Төрийн худалдан авах үйл ажиллагааны АЗ сертификаттай бол давуу тал болно		

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(И.БАТХҮҮ)

2026 оны ... дүгээр сарын ... -ны өдөр

